

ГОВЬСҮМБЭР АЙМАГ
ГЭР БҮЛ, ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУДЫН
ХӨГЖЛИЙН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2019 оны 05 сарын 16 өдөр

Дугаар А/31

Сүмбэр сум

“Гэр бүлийн аз жаргал” өдөрлөгийн
үйл ажиллагаанд хөрөнгө зарцуулах
тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Захиргааны ерөнхий хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 43 дугаар зүйлийн 43.1, 43.2, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5, Хүүхдийн эрхийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.1 дугаар заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Гэр бүлийн аз жаргал” өдөрлөгийн үйл ажиллагааны удирдамжийг 1 дүгээр хавсралтаар, төсвийг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. “Гэр бүлийн аз жаргал” өдөрлөгийн үйл ажиллагааг зохион байгуулж ажиллахыг Гэр бүлийн хөгжил оролцоо хариуцсан ажилтан /М.Уянга/-д даалгасугай.

3. Үйл ажиллагаанд зарцуулагдах 908 800 /Есөн зуун найман мянга найман зуу/ төгрөгийг нэмэлт санхүүжилтийн дансны бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардлаас гаргахыг нягтлан бодогч /Д.Оюунцэцэг/-д зөвшөөрсүгэй.

ДАРГА



Ц.ОЮУНБИЛЭГ

Д:/Бичиг хэрэг /тушаал

421190050